

**“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ” ОНӨААТҮГ-ЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2025 оны 09 дүгээр сарын 25

Улаанбаатар хот

Д/д	Хуулийн нэр	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ
1.Монгол Улсын хууль				
1	Авлигын эсрэг хууль	10.3 дахь хэсэг Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.	Үйлдвэрийн газрын хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий 7 албан тушаалд, 9 ажилтны мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан, бүртгэлд авч ажилласан.	99%
2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	30 дугаар зүйл Хуулийн этгээд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах нийтлэг үүрэг хүлээнэ:	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүргийн дагуу “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд байгууллагын ажилтан, нийтийн тээврийн жолооч нарт Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, яриа таниулга хийж ажиллаж байна.	99%

3	Жолоочийн даатгалын тухай	5 дугаар зүйл, 4 дүгээр зүйл 5.1.Тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал даатгуулна. 4.1.2.хохилогчид нөхөн төлбөр олгох;	Нийтийн тээврийн автобусны жолооч нь хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт холбогдох, зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд холбогдож бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд нөхөн төлбөрийг хуулийн дагуу барагдуулж байна. Тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгалд бүрэн хамрагдсан.	99%
4	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	20 дугаар зүйл 4/ үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох;	Үйлдвэрийн газрын дарга өөрт олгогдсон эрх, үүргийн хүрээнд өдөр тутмын үйл ажиллагаандаа уг хуулийг удирдлага болгон хэрэгжүүлж үйл ажиллагааны үндсэн чиглэлээр (А) , хүний нөөцийн чиглэлээр (Б) тушаал гарган хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.	99%

5	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай	10.1.Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна.	Үйлдвэрийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж 2025 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан нийт 25 нээлттэй тендер зарлахаас 14 нээлттэй тендерийг цахимаар зарлан, сонон шалгаруулж, гэрээ байгуулан хэргжүүлэн ажиллаж байна.	99%
6	Хөдөлмөрийн тухай хууль	3.4.Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар тусгайлан зохицуулаагүй төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг энэ хуулиар зохицуулна.	Үйлдвэрийн газар нь ажилтан, ажил олгогч нарын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлэн, мөрдөн ажиллаж, иргэн хуулийн этгээдийн эрх ашиг сонирхлыг хамгаалан, үйлдвэрийн газарт ажиллаж буй 360 ажилтан, албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан.	99%
7	Нийгмийн даатгалын ерөнхий хууль	7.2.1.өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан;	2025 оны 3 дугаар улирлын байдлаар үйлдвэрийн газарт хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа 360 ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг цаг хугацаанд нь төлж, албан журмаар даатгуулан ажиллаж байна.	99%

